



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ



**ЗАМ, ТЭЭВРИЙН
ЯАМ**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2026 он



**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
(2025 оны жилийн эцсийн байдлаар)

2026 оны 02 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-ын 6.2-т заасны дагуу хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн танилцуулж байна.

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО,
ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Тус хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Зам, тээврийн сайдын эрхлэх асуудалд хамаарах хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд гарч буй өөрчлөлтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар хэмжин, үр дүнг дүгнэхэд оршино.

“Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-ын

6.2.1-д “хэрэгжсэн” (Биелэлт бүрэн хангагдсан, нотлох баримыг бүрэн хавсаргасан-100 хувь);

6.2.2-т “хэрэгжих шатанд” (төсөв, санхүү асуудлыг шийдэж, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, холбогдох шийдвэр гарсан, удирдах дээд шатны байгууллагад өргөн барьсан-50 хувь);

6.2.3-т “хэрэгжээгүй” (шаардлагатай тооцоо, судалгаа, бэлтгэл ажил хийгдэж дууссан ч төсөв, хөрөнгөтэй холбоотой асуудал шийдвэрлэгдээгүй, хугацаа хоцорсон, биелүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй-0 хувь);

6.2.4-т “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” (хэрэгжүүлэхээр заасан хугацаа болоогүй, урт хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай болон өөрөөс хамаарах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн боловч бусад хүчин зүйлээс шалтгаалан биелэлт бүрэн хангагдаагүй-Х.Б);

6.2.5-д “хэрэгжих боломжгүй” (хуулиар эрх олгосон, бусад шийдвэрээр чиглэл өгсөн, үүрэг, даалгавар болгосон шийдвэр, зүйл, заалт доор дурдсан шаардлагуудыг хангаагүй тохиолдолд) гэж тус тус заасныг үндэслэл болгон хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Журмын 6.3-т заасан аргачлалын (томьёоны) дагуу үнэлж, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх явцад мэдээллийн чанарыг сайжруулах, бататгах, бодитой үнэлэх зорилгоор нэмэлт тодруулга, нотломж авах, асуудал хариуцсан нэгжээс тайлбар авах зэргээр ажлыг гүйцэтгэв.

Төрийн захиргааны удирдлагын газраас хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн, тус газарт ирүүлсний дагуу Монгол



Улсын Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (www.new.unelgee.gov.mn)-д тайлагнан баталгаажуулав.

Хэрэгжилтийн тайланг цахим санд оруулахдаа тухайн акт, түүнд тусгагдсан заалтын хүрсэн үр дүнг холбогдох журамд заасны дагуу хоёр мянган тэмдэгтэд багтаан, шаардлагатай нотлох баримтыг файлаар хавсарган, иж бүрэн тайлагнахыг зорьсон болно.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Зам, тээврийн сайдын эрхэлсэн асуудлын хүрээнд хамаарах 2025 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжүүлбэл зохих 269 акт, тэдгээрт тусгагдсан 585 зүйл, заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:

Хэрэгжилт гаргах нийт заалтын тоо		585
Хэрэгжсэн	Хэрэгжсэн-100 хувь	427
Хэрэгжих шатанд	Ахиц гарсан-50 хувь	45
	Тодорхой үр дүнд хүрсэн-50 хувь	4
	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай-50 хувь	57
Хэрэгжээгүй	Зохион байгуулалтаас - 0%	5
	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%	2
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Х.Б	35
Хэрэгжих боломжгүй	Хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй	1
	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	2
	Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эрх үүсвэр тодорхойгүй	3
	Хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй	1
	Хэмжигдэхүйц биш	3
Хэрэгжилтийн дундаж		89

Монгол Улсын 8 хууль 47 заалт, Улсын Их Хурлын 20 тогтоолын 43 заалт, Улсын Их Хурлын байнгын хорооны 10 тогтоолын 24 заалт, Ерөнхийлөгчийн 3 зарлигийн 4 заалт, Засгийн газрын 116 тогтоолын 178 заалт, Засгийн газрын хуралдааны 99 тэмдэглэлийн 203 заалт, Засгийн газрын 7 албан даалгаврын 80 заалт, Ерөнхий сайдын 5 захирамжийн 5 заалт, Үндэсний аюулгүй байдлын 1 зөвлөмжийн 1 заалт буюу нийт 269 тогтоол шийдвэрийн 585 заалт байна.

Эдгээрт хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд хэрэгжсэн 100 хувьтай 427 заалт, ахиц гарсан-50 хувьтай 45 заалт, тодорхой үр дүнд хүрсэн-50 хувьтай 4 заалт, удаашралтай эрчимжүүлэх шаардлагатай-50 хувьтай 57 заалт, зохион байгуулалтаас-0 хувьтай 5 заалт, санхүү хөрөнгө оруулалтаас-0 хувьтай 2 заалт, хугацаа болоогүй 35 заалт, хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй 1 заалт, хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй 2 заалт, хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй 3 заалт, хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй 1 заалт, хэмжигдэхүйц биш 3 заалт байгаа бөгөөд хэрэгжилтийн дундаж 89 хувьтай байна.



Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг шийдвэр, заалтаар гаргаж, нэгдүгээр хавсралт харуулав.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг яамны нэгж, харьяа байгууллага тус бүрээр нь гаргаж, хоёрдугаар хавсралтаар харуулав.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Засгийн газрын 103 тогтоолын 161 заалт, Засгийн газрын хуралдааны 94 тэмдэглэлийн 183 заалт, Ерөнхий сайдын 4 захирамжийн 4 заалт буюу нийт 201 тогтоол шийдвэрийн 348 заалтад хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд хэрэгжсэн 272 заалт, хэрэгжээгүй 42 заалт, хугацаа болоогүй 34 заалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа үр дүн тодорхойгүй, утга найруулгын алдаатай, заасан хугацаанаас хоцроох зэрэг алдаа дутагдал гарсаар байна.

ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ (ЗӨВЛӨМЖ)

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр Зам, тээврийн сайдад өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, яамны салбар хариуцсан нэгжүүдэд дараах санал зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

4.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан удаашралтай, эрчимжүүлэх шаардлагатай, зохион байгуулалт, санхүү, хөрөнгө оруулалт, хэрэгжих хугацаа тодорхойгүй, хэрэгжих чиг үүрэг тодорхойгүй, хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй, хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй 74 хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр цаашид хийж хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг 2026 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор яамны удирдлагад танилцуулахыг нэгжүүдийн удирдлагуудад;

4.2.Хөрөнгө санхүүжилт шаардагдахгүйгээр шийдвэрлэх боломжтой арга хэмжээний бодит үр дүнг нэмэгдүүлэх талаар, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

4.3.Нийтийн тээвэр, төмөр зам, авто замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.



Хэрэгжилт	Нийт	МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын ХТ	ЗГ-ын албан даалгавар	ЕС-ын захирамж	ҮАБЗ-ийн хурлын тогтоол	
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	269	8	20	10	3	116	99	7	5	1	
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	585	47	43	24	4	178	203	80	5	1	
Хэрэгжсэн	Хэрэгжсэн-100	427	19	32	23	4	140	160	44	4	1
Хэрэгжих шатанд	Ахиц гарсан-50	45	19	4	1	-	8	12	1	-	-
	Тодорхой үр дүнд хүрсэн-50	4	-	-	-	-	4	-	-	-	-
	Удаашралтай/Эрчимжүүлэх шаардлагатай-50	57	7	1	-	-	6	16	27	-	-
Хэрэгжээгүй	Зохион байгуулалтаас-0	5	1	-	-	-	1	2	-	1	-
	Санхүү, хөрөнгө оруулалтаас-0	2	-	-	-	-	2	-	-	-	-
Хэрэгжилтийг гооцох болоогүй	Х.Б	35	-	4	-	-	13	11	7	-	-
Хэрэгжих боломжгүй	Хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй	1	-	-	-	-	-	1	-	-	-
	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	2	1	1	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй	3	-	-	-	-	1	1	1	-	-
	Хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй	1	-	1	-	-	-	-	-	-	-
	Хэмжигдэхүйц биш	3	-	-	-	-	3	-	-	-	-
Биелэлтийн дундаж хувь		89.0	69.7	93.4	97.2	100	92.5	91.8	80.6	80	100



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

Хавсралт-2

Хэрэгжилт		Нийт	БТГ	ТЗУГ	ХШУДАГ	АЗБЗГ	АТБЗГ	СХГ	СХОГ	ИНБЗГ	ИНЕГ	МИАТ	ТЗГ	ТЗДТБЗ	ЗТХТ	АТҮТ	УБТЗ	МТЗ	ТТЗ	Д/З
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		269	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо		585	53	115	15	107	43	2	39	28	7	11	119	24	3	10	16	16	4	2
Хэрэгжсэн	Хэрэгжсэн-100	427	39	100	12	69	28	1	31	17	6	10	78	13	2	9	13	13	3	2
Хэрэгжих шатанд	Ахиц гарсан-50	45	3	2	-	5	3	1	2	1	-	-	23	3	1	-	2	1	-	-
	Тодорхой үр дүнд хүрсэн-50	4	-	-	-	1	0	-	-	3	-	-	1	-	-	-	-	1	-	-
	Удаашралтай/ Эрчимжүүлэх шаардлагатай-50	57	4	7	3	15	11	-	1	4	1	-	12	6	-	1	-	-	1	-
Хэрэгжээгүй	Зохион байгуулалтаас-0	5	1	2	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Санхүү, хөрөнгө оруулалтаас-0	2	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Хэрэгжилтийг тооцох болоогүй	Х.Б	35	6	2	-	14	-	-	3	2	-	1	4	1	-	-	-	1	-	-
Хэрэгжих боломжгүй	Хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй	1	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	2	-	-	-	-	1	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй	3	-	-	-	-	-	-	-	1	-	-	1	-	-	-	1	-	-	-
	Хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжигдэхүйц биш	3	-	1	-	2	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Биелэлтийн дундаж хувь		89.0	90.4	94.1	90.0	87.4	83.3	75.0	95.6	84.0	92.9	100	84.2	76.1	83.3	95.0	93.3	93.3	87.5	100